

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМБЫН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Г.МӨНХСҮХ
2024 оны 10 дугаар сарын 14

**ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГ ШИНЭЭР ТАРГАХ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024 оны 10-р сарын 14

Хатансуудал

Байршил: Баянлиг сум Хатансуудал 5-р баг

1. Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө.
2. Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан холболт, худгийн барилга, усны нөөцийн сав зэргийг барьж байгуулах ажил багтана. Ундны усны зориулалтын нөөцийн сав байна.
3. Усны химийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээлцэх актад хавсаргах.
4. Худгийн барилгыг өвлийн дулаалгатай зориулалтын материалаар хийгдсэн байна. Худгийн барилгын дотор багтаамж 18м^2 –ээс багагүй, дотор талдаа усан сан, халаах зуух, цооногоос усан санруу орох хоолойтой, барилга нь гадна талдаа хаяавчтай байна.

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлт	Тендерт оролцогчийн санал
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Цооногийг 159 мм-ээс багагүй голчтой өрөмдөх. Цохилтот өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд суултын янданг суурьлуулна	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 1 л/секундээс багагүй хүчин чадалтай байна	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 159 мм-ээс багагүй голчтой янданг ашиглах	
1.4	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO/ хүйтний улиралд тэсвэртэй/ стандартын шаардлага хангасан байна	
1.5	Тунгааврын гүн: 2 метрээс багагүй	
1.6	Усны чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
2	Худгийн байшин, усан сан	
2.1	Худгийн барилгыг карказ загидаж, өвлийн дулаалгатай зориулалтын материалалаар барина. Мөн доторлогоо	

	<p>хийнэ. Хэмжээ /дотор талдаа 3х3 метр, ханын өндөр шалнаас дээш 2 метр</p> <ul style="list-style-type: none"> • Материал: Төмөр, Садинг, болон бусад материалаар • Худгийн барилгын дээвэр нь төмөр материалаар хийгдсэн байна • Худгийн хаалга нь бүргэд хаалгатай байна. • Худгийн цонх нь 100х100 см хэмжээтэй / Цонхны байрлал нь наран талдаа байна/ • Худгийн барилга гадна талдаа 30 см өргөнтэй налуу хаявчтай байна 	
2.2	Усан сан нь шалнаас 50 см багагүй өндөртэй, тоноглогдсон, ундны усанд зориулагдсан 500 л –ээс багагүй багтаамжтай, тагтай сав байна. Нөөцийн сав нь цэвэрлэх боломжтой сав байна. /1 тоннын цагаан сав зөвшөөрөхгүй/, худгийн барилга дотор байрлуулна.	
2.3	Ус түгээх талбай хэсэгт гэрэлтүүлэг хийх	
3	Худгийн насос, цахилгааны утас	
3.1	Гүний насос: ISO стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх	
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлага хангасан, ус өргөх янданд 2 тутамд хавчиж тогтооно / скоч, туузаар ороож болохгүй/	
3.3	Худгийн барилгад 220ват цахилгаан холбогдсон байна.	
4	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдах гэх мэт/	
4.2	Худгийн насос ашиглах заавар, гарын авлага өгөх	
4.3	Худагт хаяг хадах, акт материалууд бэлдэх	

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН
5 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА

Амаржаргал

Б.АМАРЖАРГАЛ